



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/81/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: [Khuanganm@audit.gov.mn](mailto:Khuanganm@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

Аудитор: К.Риза

Утас: 94156768

Цахим хаяг: [Kalim\\_riza@yahoo.com](mailto:Kalim_riza@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<u>2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3. Аудитын тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.1 Ерөнхий зүйл</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.4 Материаллаг байдал</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.8 Аудитын гол асуудал</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 2ДУГААР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Т.МУРАТБЕК ТАНАА

2022.08.25 № 141  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  МХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>9747803.60</u></b>	<b><u>20571251.60</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	0.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9747803.60	20571251.60
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9747803.60	20571251.60
35410	Бичиг хэргийн материал	0.00	0.00
35420	Аж ахуйн материал	8452440.00	8778000.00
35440	Түлш, шатах тослох материал	66000.00	2852000.00
35460	Хүнсний материал	1229363.60	8941251.60
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>49804559.87</u></b>	<b><u>54985363.17</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	49804559.87	54985363.17
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	49804559.87	54985363.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	34134120.00	34134120.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4598378.64	-6897567.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20877916.00	23957916.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9361823.50	-11148042.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8935700.00	11935700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6086241.99	-6136730.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	50000.00	50000.00
39217	Ном	5853268.00	9089968.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	0.00	0.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>59552363.47</u></b>	<b><u>75556614.77</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>914310.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	914310.00	0.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	914310.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	542990.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	371320.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>58638053.47</u></b>	<b><u>75556614.77</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	58638053.47	75556614.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	41176882.00	41176882.00
51101	Өмч: - төрийн	41176882.00	41176882.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	15233389.09	32151950.39
51210	Өмнөх үеийн үр дүн	15233389.09	15233389.09
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	16918561.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2227782.38	2227782.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>59552363.47</u></b>	<b><u>75556614.77</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>269,014,116.00</b>	<b>285,261,449.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,826,616.00</b>	<b>3,420,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,826,616.00	3,420,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,826,616.00	3,420,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,826,616.00	3,420,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>267,187,500.00</b>	<b>281,841,449.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	260,131,700.00	266,309,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	260,131,700.00	266,309,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	4,487,649.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,487,649.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	7,055,800.00	11,044,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,055,800.00	11,044,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>267,260,804.44</b>	<b>268,342,887.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>267,260,804.44</b>	<b>268,342,887.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	263,278,214.44	260,834,412.08
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	212,029,600.00	209,829,300.00
210101	Үндсэн цалин	179,361,238.00	184,397,605.00
210104	Урамшуулал	19,375,562.00	11,876,470.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,292,800.00	13,555,225.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,151,000.00	28,327,000.00
210201	Тэтгэврийн даатгал	19,843,958.00	19,933,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,061,500.00	2,098,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,649,200.00	1,678,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	412,300.00	419,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,184,042.00	4,196,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,063,453.00	7,040,635.00
210301	Гэрэл, цахилгаан	948,700.00	188,000.00
210302	Түлш, халаалт	6,114,753.00	6,852,635.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,666,500.00	4,123,448.38
210401	Бичиг хэрэг	242,800.00	1,168,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,127,700.00	2,169,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	566,000.00	536,000.00
210404	Ном, хэвлэл	158,000.00	20,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	572,000.00	230,148.38
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6,310,800.00	6,140,832.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,400.00	364,970.00
210502	Хоол, хүнс	5,485,400.00	5,435,492.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	775,000.00	340,370.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	500,000.00

210604	Урсгал засвар	-	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	322,000.00	105,800.00
210702	Дотоод албан томилолт	322,000.00	105,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	450,000.00	631,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	319,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	312,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,284,861.44	4,135,896.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,711,200.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,573,661.44	4,135,896.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,982,590.00	7,500,826.62
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,848,410.00	7,500,826.62
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,848,410.00	7,500,826.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,134,180.00	7649 -
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,753,311.56</b>	<b>16,918,561.30</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,753,311.56</b>	<b>16,918,561.30</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,176,882.00	2,227,782.38	15,233,389.09	58,638,053.47
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	41,176,882.00	2,227,782.38	15,233,389.09	58,638,053.47
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,176,882.00	2,227,782.38	15,233,389.09	58,638,053.47
D08	Тайлант үеийн үр дүн			16,918,561.30	16,918,561.30
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,176,882.00	2,227,782.38	32,151,950.39	75,556,614.77

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>267187500.00</b>	<b>281841449.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>267187500.00</b>	<b>281841449.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	260131700.00	266309800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	260131700.00	266309800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	4487649.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4487649.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	7055800.00	11044000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7055800.00	11044000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>266887500.00</b>	<b>275524749.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>266887500.00</b>	<b>275524749.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>262597220.00</b>	<b>269035100.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	212350200.00	209829300.00
210101	Үндсэн цалин	179361238.00	184605100.00
210104	Урамшуулал	19375562.00	11610800.00
210105	Гэрээт ажлын хөлс	13613400.00	13613400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27830400.00	28327000.00
210201	Тэтгэврийн даатгал	19523358.00	19933800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2061500.00	2098300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1649200.00	1678600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	412300.00	419700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4184042.00	4196600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7055800.00	10544000.00
210301	Гэрэл, цахилгаан	948700.00	661000.00
210302	Түлш, халаалт	6107100.00	9883000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2686600.00	2875400.00
210401	Бичиг хэрэг	244400.00	92600.00
210402	Тээвэр, шатахуун	1127700.00	1696000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	595700.00	571000.00
210404	Ном, хэвлэл	159900.00	132300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	558900.00	383500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	5783600.00	14800600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50400.00	247700.00
210502	Хоол, хүнс	4963200.00	14108900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	770000.00	444000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	500000.00
210604	Урсгал засвар		500000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	322000.00	105800.00
210702	Дотоод албан томилолт	322000.00	105800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	450000.00	532300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		132300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450000.00	400000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6118620.00	1520700.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6118620.00	1520700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4290280.00</b>	<b>6482000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3156100.00	6482000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3156100.00	6482000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1134180.00	7649
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>300000.00</u></b>	<b><u>6316700.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>300000.00</b>	<b>6316700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>300000.00</b>	<b>6316700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	300000.00	6316700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	300000.00	6316700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-300000.00</u></b>	<b><u>-6316700.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	280209200.00	266059320.00	277353800.00	277353800.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	280209200.00	266059320.00	277353800.00	277353800.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	277053100.00	262903220.00	270871800.00	270871800.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	212350200.00	212356200.00	209829300.00	209829300.00
210101	Үндсэн цалин	179340600.00	179367238.00	184605100.00	184605100.00
210104	Урамшуулал	19396200.00	19375562.00	11610800.00	11610800.00
210105	Гэрээт ажлын хөлс	13613400.00	13613400.00	13613400.00	13613400.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27830400.00	27830400.00	28327000.00	28327000.00
210201	Тэтгэврийн даатгал	19584400.00	19523358.00	19933800.00	19933800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2061500.00	2061500.00	2098300.00	2098300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1649200.00	1649200.00	1678600.00	1678600.00
210204	Ажигүйдлийн даатгал	412300.00	412300.00	419700.00	419700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4123000.00	4184042.00	4196600.00	4196600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7055800.00	7055800.00	10544000.00	10544000.00
210301	Гэрэл, цахилгаан	660800.00	948700.00	661000.00	661000.00
210302	Түлш, халаалт	6395000.00	6107100.00	9883000.00	9883000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9157000.00	2686600.00	2775400.00	2775400.00
210401	Бичиг хэрэг	244400.00	244400.00	92600.00	92600.00
210402	Тээвэр, шатахуун	1417500.00	1127700.00	1596000.00	1596000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	679400.00	595700.00	571000.00	571000.00
210404	Ном, хэвлэл	177700.00	159900.00	132300.00	132300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үйлчилгээ	68800.00	0.00		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6569200.00	558900.00	383500.00	383500.00
2105	<b>Нормативт зардал</b>	12087800.00	5813600.00	14620600.00	14620600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67100.00	50400.00	67700.00	67700.00
210502	Хоол, хүнс	4993200.00	4993200.00	14108900.00	14108900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7027500.00	770000.00	444000.00	444000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500000.00	0.00	500000.00	500000.00
210604	Урсгал засвар	500000.00	0.00	500000.00	500000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	333300.00	322000.00	105800.00	105800.00
210702	Дотоод албан томилолт	333300.00	322000.00	105800.00	105800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал</b>	627700.00	450000.00	532300.00	532300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил	177700.00	0.00	132300.00	132300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоосон ажил	450000.00	450000.00	400000.00	400000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7110900.00	6388620.00	3637400.00	3637400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал				
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7110900.00	6388620.00	3637400.00	3637400.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3156100.00	3156100.00	6482000.00	6482000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3156100.00	3156100.00	6482000.00	6482000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3156100.0	3156100.0	6482000.0	6482000.0
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	0.00	277353800.00	277353800.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	0.00	0.00	266309800.00	266309800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			266309800.00	266309800.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	0.00	0.00	11044000.00	11044000.00
132001	Орон нутгийн төсвөөс			11044000.00	11044000.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	0.00	0.00	18.00	21.00
620001	Удирдах ажилтан			1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан			7.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан			10.00	12.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	4480000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	4480000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	4480000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2300000.00	
210401	Бичиг хэрэг			
210402	Тээвэр, шатахуун		100000.00	
210404	Ном, хэвлэл		2200000.00	
2105	<b>Нормативт зардал</b>	0.00	180000.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		180000.00	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	2000000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2000000.00	
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	4480000.00	
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	4480000.00	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сагсай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн эрхэм зорилго нь “Суралцагчдын хэрэгцээнд суурилсан хүртээмжтэй, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй болгон хүүхдэд сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмшүүлэх бэлтгэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус сургуулийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 267.3 сая төгрөгийн 2 хувиар буюу 5.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Сагсай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16.0 сая төгрөгөөр буюу 26.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Бараа материал	9747.8	20571.2	10823.4
Үндсэн хөрөнгө	49804.6	54985.4	5180.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>59552.4</b>	<b>75556.6</b>	<b>16004.2</b>
Өр төлбөр	914.3		(914.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	58638.0	75556.6	16918.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>59552.4</b>	<b>75556.6</b>	<b>16004.2</b>

Мөнгөн хөрөнгө, авлага данс оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 20.5 сая төгрөг болж 10.8 сая төгрөгөөр нэмэгдсэний дотор хүнсний үлдэгдэл оны эхнээс 8.0 сая төгрөгөөр, түлшний үлдэгдэл 2.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 0.6 сая төгрөгийн бичиг хэрэг, 2.5 сая төгрөгийн аж ахуйн материал, 12.0 сая төгрөгийн түлш шатахуун, 20.6 сая төгрөгийн хүнсний материал, 0.1 сая төгрөгийн эм боох материал нийтдээ 35.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан ба 0.4 сая төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээж авч нийтдээ 36.2 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, 25.4 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зохих зарлагын баримтуудыг үндэслэн зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 54.9 сая төгрөг болж 5.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр тайлант онд 3.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 3.2 сая төгрөгийн ном нийтдээ 6.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан ба 3.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг Орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгө данс тайлант онд байгуулсан элэгдлийн зардлын дүнгийн зөрүүгээр оны эхнээс 5.2 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Аймгийн Санхүү, Төрийн Сангийн хэлтсийн зөвшөөрсний дагуу хичээл практикийн зардлаас 2.5 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авч, нэмэлт санхүүжилтээр 3.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Оны эхэнд 0.9 сая төгрөгийн татвар болон бараа үйлчилгээний зардлын өртэй байсныг бүрэн барагдуулж оны эцэст өр төлбөр гараагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 16.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 285.2 сая төгрөг болж өмнөх оноос 16.2 сая төгрөгөөр өссөн нь урсгал зардлын болон нэмэлт санхүүжилтийн хэмжээ өссөн, үнэ төлбөргүй хүлээж авсан орлогын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 268.3 сая төгрөг болж өмнөх оноос 1.0 сая төгрөгөөр өссөн нь урьд оноос хангамж бараа материалын зардал, цалин НДШ-ийн зардал 1.7-2,5 сая төгрөгөөр буурсан, үдийн цайны зардал, бусад бараа үйлчилгээний зардлуудын өсөлт зэрэг нь нөлөөлжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд санхүүжилтийн орлогыг 268.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 268.4 сая төгрөгөөр тооцон төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 16 дугаар тогтоолоор сургуулийн 2020 оны төсвийг төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1.7 сая төгрөгөөр бууруулан 266.7 сая төгрөгөөр баталжээ.

Нийт төсвийн 255.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 11.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тогтоолоор баталсан төсвийн тодотголоор цалин, НДШ-ийн зардлыг 13.2 сая төгрөгөөр нэмж, нормативт зардлыг 2.5 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлын төсвийг 2.5 сая төгрөгөөр бууруулж тодотгон тусгай зориулалтын дэмжлэгээс авах санхүүжилтийн хэмжээг 10.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт төсвийг 277.4 сая төгрөгөөр баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 266.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 11.0 сая төгрөгийн нийтдээ 277.3 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 277.3 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 85.8 хувийг цалин, НДШ-ийн зардал, 3.8 хувийг тогтмол зардал, 1.0 хувийг хангамж бараа материалын зардал, 5.3 хувийг норматив зардал, 4.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Зардлуудад хийсэн түүвэр, горим сорилын дүнгээс үзэхэд хүүхдийн хоолны зардал болон үдийн цайны хүнсний зүйлийг орлогод авахад нэгтгэж авснаас үдийн цайнд батлагдсан төсвийн хэмжээнээс 1018.8 мянган төгрөгийн хүнсний зүйлийг илүү олгож, хүүхдийн хоолны зардлаас гүйлгэн зарцуулагдсан байна.

Иймд цаашид төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, зардлын зүйл ангиар зориулалтын дагуу зарцуулах талаар зөвлөмж өгөгдөв.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Аймгийн Боловсролын газраас 4.5 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр олгосныг номын фондод ном худалдан авахад 3.2 сая төгрөг, 0.6 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч, 0.7 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулж санхүүгийн тайландаа тусгажээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Сагсай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

Байгууллагын сургалтын үйл ажиллагаа ковидтой холбоотойгоор танхимаар болон цахимаар явагдаж ирсэн, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн горим сорилын дүнгээр үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлуудад цалингийн зардалд 209.8 сая төгрөг, НДШ-ийн зардалд 28.3 сая төгрөг, халаалтын зардалд 9.9 сая төгрөг, хүүхдийн хоолны зардалд 14.1 сая төгрөг, үдийн цайны зардалд 6.5 сая төгрөг нийтдээ **268.6** сая төгрөг зарцуулсан байна.

Тус сургуулийн нийт санхүүжилт 277.4 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 268.6 сая төгрөгийн зардлыг хасаж 8.7 сая төгрөгийг тэвчиж болох зардал гэж үзээд Засгийн газрын тогтоолын дагуу уг зардлын 10 хувь болох 0.9 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна.

Сургууль нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна..

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал 277.3 сая төгрөгийн 149 мэдээллээс 254.2 сая төгрөгийн 144 мэдээллийг хугацаандаа байршуулж, 2021 оны 4 дүгээр сард сар бүр мэдээлэх 3 мэдээлэл, тухай бүр мэдээлэх 2 мэдээлэл нийт 5 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ гараагүй байна.

Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогод санхүүжилтийн 277.3 сая төгрөгийн 12 удаагийн мэдээллийг байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан мэдээлэл оруулсан байдлын хэрэгжилтийн хувь 95.7 хувьтай байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, 2.4 сая төгрөгийн зөрчилд акт тогтоосноос актыг барагдуулж, зөвлөмжийн биелэлтийг хугацаандаа ирүүлжээ.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 2.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс тайлагналтай холбоотой 1,0 сая төгрөгийн алдааг залруулж, 0,9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

### **4.1 Залруулсан алдаа**

Үр дүнгийн тайланд хоолны зардлыг 642.9 мянган төгрөгөөр дутуу, тээвэр шатахууны зардлыг мөн хэмжээгээр илүү тайлагнасан мөн үдийн цайны зардлыг 324.7 мянган төгрөгөөр дутуу, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд мөн хэмжээгээр илүү тайлагнасныг залруулж, хэрэгжүүлсэн горим, сорилын дүнг үндэслэн Үр дүнгийн тайланд 967,6 мянган төгрөгийн залруулга хийлээ.

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Аудитаар нийт 0.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Үүнд:

Тус сургууль нь Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолд заасны дагуу шалгахад тэвчиж болох бусад урсгал зардал 8.7 сая төгрөгийг 10 хувиар буюу 0.9 сая төгрөгөөр хэмнэж ажиллах ёстой боловч хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлаас хэмнэлт гаргаагүй 0.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үүнд:

#### **1.1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Сурагчдын үдийн цайнд 1018.8 мянган төгрөгийн хүнсний зүйлийг батлагдсан төсвөөс илүү олгож, хүүхдийн хоолны зардлаас гүйлгэн зарцуулсан байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын дагуу төсөвт зохих зохицуулалт хийж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагсай сумын Ерөнхий боловсролын 2дугаар сургууль	3	2.9	1	1.0			1	0.9	1	1.0